ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/209/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

**Агуулга**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 12
3. Аудитын тайлан ........ 13
3.1 Ерөнхий зүйл ........ 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........ 14
3.4 Материаллаг байдал........ 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 16
3.8 Аудитын гол асуудал........ 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
4. Аудитын илрүүлэлт........ 18
4.1 Залруулсан алдаа........ **Error! Bookmark not defined.**
4.3 Албан шаардлага........ 18
4.4 Зөвлөмж ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/64
танай________________-ны №____________________-т

ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.АЛТАНХУЯГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020254

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **54,269,025.00** | **55,132,225.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 54,269,025.00 | 55,132,225.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 36,426,775.00 | 34,098,775.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 36,426,775.00 | 34,098,775.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 17,842,250.00 | 21,033,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,715,000.00 | 20,973,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 67,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 60,250.00 | 60,250.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,627,464,108.83** | **3,583,759,227.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,627,464,108.83 | 3,583,759,227.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,164,010,108.83 | 3,120,305,227.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,593,301,132.32 | 2,653,245,611.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (194,941,696.10) | (249,814,452.02) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 68,400,000.00 | 68,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (36,900,000.00) | (41,100,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 115,507,649.00 | 128,157,709.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (104,902,285.69) | (109,447,564.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 44,101,598.89 | 44,101,598.89 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,569,932.39) | (38,049,932.47) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 834,028,070.00 | 834,028,070.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (118,014,427.20) | (169,215,812.64) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 463,454,000.00 | 463,454,000.00 |
| 39301 | Програм хангамж | 495,000.00 | 495,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (495,000.00) | (495,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 463,454,000.00 | 463,454,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,681,733,133.83** | **3,638,891,452.17** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,681,733,133.83** | **3,638,891,452.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,681,733,133.83 | 3,638,891,452.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 463,454,000.00 | 463,454,000.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 463,454,000.00 | 463,454,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,143,011,079.61 | 3,100,169,397.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,143,011,079.61 | 3,143,011,079.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (42,841,681.66) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 75,268,054.22 | 75,268,054.22 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,681,733,133.83** | **3,638,891,452.17** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **814,074,200.00** | **748,638,199.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **54,438,500.00** | **67,590,999.82** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 54,438,500.00 | 67,590,999.82 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 54,438,500.00 | 67,590,999.82 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,988,500.00 | 5,256,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,650,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 38,800,000.00 | 62,334,999.82 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **759,635,700.00** | **681,047,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 733,945,700.00 | 641,129,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 733,945,700.00 | 329,635,800.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 311,494,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,690,000.00 | 39,917,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 31,143,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,690,000.00 | 8,774,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **880,227,291.44** | **791,479,881.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **880,227,291.44** | **791,479,881.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 815,163,067.59 | 756,410,089.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,445,332.34 | 235,900,785.26 |
| 210101 | Үндсэн цалин | 187,187,924.22 | 177,158,587.43 |
| 210102 | Нэмэгдэл | 41,257,408.12 | 58,742,197.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,384,088.81 | 31,016,006.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,452,964.25 | 21,755,853.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,285,443.84 | 2,366,237.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,825,010.04 | 1,892,989.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 438,242.95 | 448,692.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,382,427.73 | 4,552,233.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 368,305,109.00 | 299,769,916.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,793,558.00 | 6,873,950.84 |
| 210302 | Түлш, халаалт | 356,854,400.00 | 290,259,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,657,151.00 | 2,636,766.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,081,056.00 | 10,265,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,193,200.00 | 889,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,133,000.00 | 2,234,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 840,000.00 | 1,181,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 360,000.00 | 510,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,430,200.00 | 1,524,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,124,656.00 | 3,925,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,829,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,829,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 600,000.00 | 916,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 | 916,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,124,900.00 | 5,516,750.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,172,900.00 | 3,859,085.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 199,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 152,500.00 | 15,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 70,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 967,865.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 150,393,581.44 | 172,024,731.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,852,200.00 | 55,994,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 111,541,381.44 | 116,029,881.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 65,064,223.85 | 35,069,791.54 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,106,600.00 | 23,475,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,106,600.00 | 22,975,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 34,957,623.85 | 11,593,891.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(66,153,091.44)** | **(42,841,681.66)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(66,153,091.44)** | **(42,841,681.66)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 2,950,686.14 | 2,822,861,287.94 | 2,825,811,974.08 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -59,206,100.00 | -59,206,100.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **2,950,686.14** | **2,763,655,187.94** | 2,766,605,874.08 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 215,550,000.00 | 00.00 | 559,641,350.55 | 775,191,350.55 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **463,454,000.00** | **75,268,054.22** | **3,143,011,079.61** | 3,681,733,133.83 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **463,454,000.00** | **75,268,054.22** | **3,143,011,079.61** | 3,681,733,133.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **463,454,000.00** | **75,268,054.22** | **3,143,011,079.61** | 3,681,733,133.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -42,841,681.66 | -42,841,681.66 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **463,454,000.00** | **75,268,054.22** | **3,100,169,397.95** | 3,638,891,452.17 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **775,274,200.00** | **686,303,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,138,500.00** | **5,256,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,138,500.00 | 5,256,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,138,500.00 | 5,256,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,988,500.00 | 5,256,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **773,135,700.00** | **681,047,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 733,945,700.00 | 641,129,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 733,945,700.00 | 329,635,800.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 311,494,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,190,000.00 | 39,917,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 31,143,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,690,000.00 | 8,774,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,500,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **773,774,200.00** | **676,313,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **773,774,200.00** | **676,313,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **708,709,976.15** | **640,943,408.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,223,852.83 | 235,900,785.26 |
| 210101 | Үндсэн цалин | 187,187,924.22 | 177,158,587.43 |
| 210102 | Нэмэгдэл | 41,035,928.61 | 58,742,197.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,605,568.32 | 31,016,006.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,674,443.76 | 21,755,853.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,285,443.84 | 2,366,237.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,825,010.04 | 1,892,989.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 438,242.95 | 448,692.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,382,427.73 | 4,552,233.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 367,770,105.00 | 299,769,916.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,367,186.00 | 6,873,950.84 |
| 210302 | Түлш, халаалт | 356,854,400.00 | 290,259,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,548,519.00 | 2,636,766.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,743,900.00 | 7,001,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,199,200.00 | 889,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,200,000.00 | 2,167,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 840,000.00 | 1,181,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 360,000.00 | 510,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,144,700.00 | 2,252,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 1,391,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,391,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,829,000.00 | 4,093,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,890,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 203,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,829,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 600,000.00 | 916,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 | 916,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,124,900.00 | 5,133,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,172,900.00 | 5,133,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 199,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 152,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,421,650.00 | 57,112,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,421,650.00 | 57,112,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,064,223.85** | **35,369,791.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,106,600.00 | 23,775,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,106,600.00 | 22,975,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 34,957,623.85 | 11,593,891.54 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 34,957,623.85 | 11,593,891.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,500,000.00** | **9,990,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,500,000.00** | **9,990,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,500,000.00** | **9,990,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,500,000.00 | 9,990,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,500,000.00 | 9,990,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,500,000.00)** | **(9,990,000.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 651,129,900.00 | 634,792,008.46 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 651,129,900.00 | 634,792,008.46 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 627,654,000.00 | 611,316,108.46 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,910,800.00 | 235,900,785.26 |
| 210101 | Үндсэн цалин | 186,386,000.00 | 177,158,587.43 |
| 210102 | Нэмэгдэл | 49,524,800.00 | 58,742,197.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,847,900.00 | 31,016,006.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,411,500.00 | 21,755,853.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,359,100.00 | 2,366,237.74 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,887,300.00 | 1,892,989.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 471,800.00 | 448,692.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,718,200.00 | 4,552,233.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 310,494,100.00 | 299,769,916.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,088,700.00 | 6,873,950.84 |
| 210302 | Түлш, халаалт | 290,259,200.00 | 290,259,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,146,200.00 | 2,636,766.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,735,500.00 | 6,720,450.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 889,400.00 | 889,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,167,500.00 | 2,167,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 941,700.00 | 941,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 510,300.00 | 510,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,226,600.00 | 2,211,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,204,200.00 | 1,203,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 204,200.00 | 203,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 921,000.00 | 916,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 921,000.00 | 916,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,133,400.00 | 5,133,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,133,400.00 | 5,133,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,407,100.00 | 30,656,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,407,100.00 | 30,656,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,475,900.00 | 23,475,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,475,900.00 | 23,475,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,975,900.00 | 22,975,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 651,129,900.00 | 634,792,008.46 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 329,635,800.00 | 328,766,091.62 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 329,635,800.00 | 328,766,091.62 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 311,494,100.00 | 300,769,916.84 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 311,494,100.00 | 300,769,916.84 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 10,000,000.00 | 5,256,000.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,000.00 | 5,256,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9.00 | 9.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **39,917,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **39,917,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 39,617,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 280,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 40,550.00 |
| **2105** | **Нормативт зардал** | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,880,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,880,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,456,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,456,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 39,917,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,917,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,143,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,774,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь Хүний хөгжил-эрүүл мэндийг дэмжин иргэдийг идэвхитэй хөдөлгөөнд уриалан, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан, иргэдийг дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцөлийг сайжруулах зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын дотоод хяналт шалгалтын коммис нь жилийн ажлын төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгууллагын даргаар батлуулан ажилласан байна. Нийт 14 удаагийн хяналт шалгалтаар зөвлөмж өгсөн байна.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 748,638.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,229.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,983.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөлгүй 8,983.6 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

***Орлого:***

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 329,635.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 311,494.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 5,256.0 мянган төгрөг, Биеийн тамир спортын улсын хорооноос 8,774.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс 31,143.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 62,334.9 мянган төгрөг нийт 748,638.1 мянган төгрөг, өмнөх оноос 65,436.0 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна. Энэ нь санхүүжилт буурсантай холбоотой байна.

***Зардал:***

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 791,479.8 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 676,313.2 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 634,792.0 мянган төгрөг зарцуулсан байна.

***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:***

Тус байгууллага төрийн сангийн 100140008009 тоот дансанд 2021 онд 335,522.8 мянган төгрөгийн орлого, 335,522.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 100140035013 тоот дансанд 2021 онд 311,494.1 мянган төгрөгийн орлого, 311,494.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн 100140035401 тоот дансанд 39,917.3 мянган төгрөгийн орлого орж, 39,917.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян.төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 54,269.0 | 55,132.2 | 863.2 |
| Үндсэн хөрөнгө | 3,627,464.1 | 3,583,759.2 | -43,704.8 |
| Нийт хөрөнгө | **3,681,733.1** | **3,638,891.4** | **-42,841.6** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,681,733.1 | 3,638,891.4 | -42,841.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | **3,681,733.1** | **3,638,891.4** | **-42,841.6** |

Бараа материалын дансны үлдэгдэл 55,132.2 мянган төгрөг болж 863.2 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,583,759.2 мянган төгрөг болж 43,704.8 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь нэмэлт санхүүжилтийн дансны худалдан авалтаар 9,990.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 62,604.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,638,891.4 мянган төгрөг болж 42,841.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,097,677.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,097,677.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 446,547.7 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 329,635.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 311,494.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, НДШ, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 651,129.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 329,635.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 329,635.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 311,494.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 5,256.0 мянган төгрөг нийт 646,385.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 634,792.0 мянган төгрөгийг зарцуулж, 11,593.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 634,792.0 мянган төгрөг буюу 97,5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлын зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Биеийн тамир спортын газар тайлант онд Биеийн тамир спортын улсын хорооноос 8,774.0 мянган төгрөг, Аймгийн төсвөөс 31,143.3 мянган төгрөг нийт 39,917.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс тоног төхөөрөмж худалдан авахад 12,880.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 280.5 мянган төгрөг, шагнал урамшуулалд 300.0 мянган төгрөг, уралдаан тэмцээний зардалд 26,456.7 мянган төгрөг нийт 39,917.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Биеийн тамир спортын газарт тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан боловч гүйцэтгэлээр 5,256.0 мянган төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөө 48 хувиар тасарсан нь цар тахлын хязгаарлалтаас шалтгаалсан байна.

Засгийн Газрын тохируулагч агентлаг биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 18 ны өдрийн А/97 тоот тушаалаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, Цахим фитнесс төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэл,9 дүүргийн Биеийн тамир Спортын хороодод Ухаалаг дэлгэц худалдан авч нийлүүлэх, тоног төхөөрөмж авах зардлаар 9,990.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь үндсэн үйл ажиллагааны орлого 5,256.0 мянган төгрөгийн гэрээ байгуулаагүй, гүйцэтгэл болон мандатын тоонд үндэслэн аккруэл сууриар бүртгээгүй байна.

Худалдан авалтуудыг Э-баримтаар бүрэн баримтжуулдаггүй, гэрээнд тусгадаггүй, хянаж ажилладаггүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, мэдээлэлгүй 3 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн үйл ажиллагааны төлөвлөлт, худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулахтай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 21 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын бүртгэл, гэрээ, гэрээний хэрэгжилт, авлагын талаар дараагийн аудитаар анхаарах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,505.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,256.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 13,249.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

### 4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 13,249.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Төв аймгийн Биеийн тамир спортын газар нь үндсэн үйл ажиллагааны орлого 5,256.0 мянган төгрөгийн гэрээ байгуулаагүй, гүйцэтгэл болон мандатын тоонд үндэслэн аккруэл сууриар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д ”Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Заалны орлогыг байгуулсан гэрээ, гүйцэтгэл, мандатын тоонд үндэслэн акруэль сууриар бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа зөрчил</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>дүн</th><th>Тоо</th><th>дүн</th><th>Тоо</th><th>дүн</th><th>Тоо</th><th>дүн</th><th>Тоо</th><th>дүн</th></tr>
<tr><td>1</td><td>Биеийн тамир Спортын газар</td><td>2</td><td>18,505.0</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>13,249.0</td><td>1</td><td>5,256.0</td></tr>
</table>